



НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Газрын зөвлөлийн хурлын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын эмнэлгийн дагаж мөрдөх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Эмнэлгийн нөхөн сэргээх зарим үйлчилгээг төлбөртэй үзүүлэх журам"-ыг хоёрдугаар хавсралтаар, "Төлбөртэй үйлчилгээний үнэ тариф"-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжитэнд хяналт тавьж, эмнэлгийн үйлчилгээг өдөр тутмын удирдлагаар хангаж ажиллахыг Их эмч /Г.Ган-Эрдэнэ/-д, үйлчилгээнээс олсон орлогод хяналт тавьж, уг орлогоор эмнэлгийн тусламж үйлчилгээний материалын хангалт хийж ажиллахыг тооцооны нягтлан бодогч /Д.Очирбат/-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ш.ОДОНЧИМЭГ

1150500747



Нийслэлийн Нийтлэг Үйлчилгээний газрын
 даргын Тамгын Газарын 11-ны өдрийн
 тушаалын 1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
 ЭМНЭЛГИЙН ӨРӨӨНД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ

Үндсэн зорилго нь: Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний ажлын алба, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх орчин нөхцлийг бүрдүүлж, үйлчлэх дэг журмыг тогтооход оршино.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний ажлын алба, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн эмнэлгийн байгууллагын зүгээс бичиж өгсөн эм тариаг тогтоосон цагуудад нь хийх ба эмийн бус эмчилгээний тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлнэ.

1.2. Эмнэлгийн ажилтан нь нөхөн сэргээх мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд үйл ажиллагаандаа мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, тушаал шийдвэрийг мөрдөж ажиллахаас гадна стандартын шаардлага хангасан, шалгуур үзүүлэлтүүдэд тохирсон ажил үйлчилгээг үзүүлнэ.

Хоёр. Эмчилгээний цагийн хуваарь

2.1. Эмчилгээг ажлын өдрийн 08.30 цагаас 17.30 цаг хүртлэх хугацаанд багтаан хийнэ.

2.2. Үдийн цай 12.30-13.30 цагт үргэлжилнэ.

Гурав. Техник, төхөөрөмж ашиглалт

3.1. Эмчилгээний тоног төхөөрөмж, техник хэрэгслийг зөвхөн эмч болон эмчийн зөвшөөрлөөр сувилагч ажиллуулна.

3.2. эмчилгээний тоног төхөөрөмж, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг эмч болон сувилагч хариуцна.

Дөрөв. Эмчилгээ, үйлчилгээ

4.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Нийтлэг үйлчилгээний газрын албан хаагчдад үнэ төлбөргүй эм эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх бөгөөд дээрх байгууллагаас бусад нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад "Эмнэлгийн нөхөн сэргээх зарим үйлчилгээг төлбөртэй үзүүлэх журам", баталсан тарифын дагуу үйлчилгээ үзүүлнэ.



ЭМНЭЛГИЙН НӨХӨН СЭРГЭЭХ ЗАРИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨЛБӨРТЭЙ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдад эрүүл мэндийн нөхөн сэргээх зарим үйлчилгээг төлбөртэй үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Нөхөн сэргээх эмчилгээний төрөл

- 2.1. Бариа /толгой, хүзүү, хөл, нүүрний цэгийн иллэг, дээд мөч, доод мөч, хэсэгчилсэн бүтэн биеийн массаж/
- 2.2. Тарилга /судас, булчин, арьсан дор, дусал/
- 2.3. Бумба /галт, соруул, гулгуур/
- 2.4. Зүү
- 2.5. Төөнүүр
- 2.6. Шивүүр
- 2.7. Массажны аппарат /массажны ор./
- 2.8. Зөгийн балтай татлага
- 2.9. Шарлага
- 2.10. Шарх, боолт цэвэрлэх

Гурав. Нөхөн сэргээх зарим үйлчилгээг төлбөртэй үзүүлэхэд тавигдах шаардлага, орлогын зарцуулалт

3.1. Эмч нь өрхийн болон нарийн мэргэжлийн эмчийн заалтын дагуу үйлчлүүлэгчийн хүсэлтээр эмчилгээ сувилгааг хийнэ.

3.2. Эмч нь Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын даргын тушаалаар батлагдсан тарифын дагуу төлбөрийг байгууллагын бэлэн мөнгөний касс ташаасан баримттай үйлчлүүлэгчид үйлчилж, үзүүлсэн үйлчилгээний тооцоог сар бүрийн 25-ны дотор Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын нягтлан бодогчтой хийсэн байна.

3.3. Төлбөртэй үйлчилгээний орлогод Нийтлэг үйлчилгээний газрын нягтлан бодогч хяналт тавьж, уг орлогоор эмнэлгийн тусламж, үйлчилгээний материалын хангалт хийж ажиллана.

Дөрөв. Хориглох зүйлс

4.1. Энэхүү журмаар тогтоосон нөхөн сэргээх үйлчилгээнээс өөр эмчилгээ үйлчилгээг төлбөртэй хийх

4.2. Нөхөн сэргээх үйлчилгээний тогтоосон төлбөрийн хэмжээнээс өөр төлбөр авах



МОНГОЛЫН ЭМНЭЛГИЙН НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
 ДЭГЭС 2016 оны 11 сарын 11-ны өдрийн
 тушаалын 3 дугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН НӨХӨН СЭРГЭЭХ ЗАРИМ
 ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨЛБӨРТЭЙ ҮЗҮҮЛЭХ ТАРИФ

№	Хийгдэх эмчилгээ	Үнэ
Бариа:		
1	Толгой, хүзүүний бариа	3000₮
2	Нуруун бариа	3000₮
3	Даралт бууруулах бариа	3000₮
4	Нүүрний цэгэн иллэг	3000₮
5	Дээд мөчдийн бариа	3000₮
6	Доод мөчдийн бариа	5000₮
7	Бүтэн биеийн бариа	10000₮
Тарилга:		
8	Судас	1500₮
9	Булчин	1000₮
10	Дусал	2500₮
11	Арьсан дор	1000₮
Бумба:		
12	Галт	2000₮
13	Соруул	1500₮
14	Гулгуур	2000₮
Бусад:		
15	Зүү	2000₮
16	Төөнүүр	2000₮
17	Шивүүр	3000₮
18	Шарлага	1500₮
19	Массажны ор	5000₮
20	Зөгийн балтай татлага	2000₮
21	Шарх боолт цэвэрлэх	2000₮
22	Нарру dream аппарат	1500₮
23	Doctor life аппарат	1500₮
24	Seragem аппарат	1500₮
25	Хүзүүний аппарат	1500₮